



ДОРНОГОВЬ АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 8/03

Сайншанд сум

С.Цэрэндолгорт жирэмсний болон
амаржсаны амралт олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалт, 61 дүгээр зүйлийн 61.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 137 дугаар зүйлийн 137.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Сэргэлэнбаатарын Цэрэндолгорт жирэмсний болон амаржсаны амралтыг 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн чөлөөг олгосугай.

2.С.Цэрэндолгорын үүрэгт ажлыг тэмдэглэл үйлдэн хүлээлцэхийг Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга (Ц.Баярмаа)-д үүрэг болгосугай.

3.С.Цэрэндолгортой холбогдох тооцоог хийж дуусгахыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Сайнтуяа)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ОЛЗБАЯР

442801005



ДОРНОГОВЬ АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 03 сарын 02 өдөр

Дугаар Б/ОК

Сайншанд сум

Ц.Оюунцэцэгийн хүүхэд асрах чөлөөг дуусгаж,
албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь заалт, 41.4 дэх заалт, 61 дүгээр зүйлийн 61.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 139 дүгээр зүйлийн 139.2 дахь заалт, 140 дүгээр зүйлийн 140.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын Улаанбадрах сумын газрын даамал Цэрэнноровын Оюунцэцэгийн өөрийн гаргасан хүсэлтийг үндэслэн 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн хүүхэд асрах чөлөөг дуусган албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулсугай.

2.Ц.Оюунцэцэгийн албан тушаалын үндсэн цалинг ТЗ-9 дүгээр зэрэглэлээр, албан тушаалын цалингаас төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 4 хувь, орон нутагт ажилласны нэмэгдэл 40 хувиар (Улсын төсөв) тус тус тооцож олгохыг ерөнхий нягтлан бодогч (Д.Сайнтуяа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ОЛЗБАЯР

14426010046



ДОРНОГОВЬ АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 03 сарын 02 өдөр

Дугаар Б/05

Сайншанд сум

Б.Алдарбаярыг гэрээт инженерээр
ажиллуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Иргэний хуулийн 343 дугаар зүйлийн 343.1 дэх заалт, 344 дүгээр зүйлийн 344.1 дэх заалт, 348 дугаар зүйлийн 348.1 дэх заалт, Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны “Барилга захиалагчийн хяналтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 83 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Барилгын захиалагчийн хяналт хэрэгжүүлэхтэй холбогдуулан Батсуурийн Алдарбаярыг 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн барилга захиалагчийн хяналтын гэрээт инженерээр ажиллуулсугай.

2.Б.Алдарбаяртай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, гэрээний биелэлтийг хяналт тавьсан тухай бүр дүгнэж ажиллахыг Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга (Ц.Баярмаа), ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллахыг барилга захиалагчийн хяналтын гэрээт инженер (Б.Алдарбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Барилга захиалагчийн хяналтын гэрээт инженер Б.Алдарбаярын сарын цалинг 2,000,000 (Хоёр сая) төгрөгөөр тооцож, барилгын техник хяналтын зардлаас олгохыг ерөнхий нягтлан бодогч (Д.Сайнтуяа) -д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ОЛЗБАЯР

4426010082



ДОРНОГОВЬ АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 8/10

Сайншанд сум

С.Ганбатыг гэрээт жолоочоор ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.4, 16.5.5, Иргэний хуулийн 343 дугаар зүйлийн 343.1 дэх заалт, 344 дүгээр зүйлийн 344.1 дэх заалт, 348 дугаар зүйлийн 348.1 дэх заалт, Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны "Барилга захиалагчийн хяналтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 83 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын хэвийн үйл ажиллагаа хангах зорилгоор Содномпэлийн Ганбатыг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн гэрээт жолоочоор ажиллуулсугай.
2. С.Ганбаттай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн (Б.Батбаатар)-т үүрэг болгосугай.
3. Гэрээт жолооч С.Ганбатын сарын цалинг 1,800,000 (Нэг сая найман зуун мянган) төгрөгөөр тооцон барилгын техник хяналтын зардлаас олгохыг ерөнхий нягтлан бодогч (Д.Сайнтуяа) -д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ОЛЗБАЯР

4426010093



ДОРНОГОВЬ АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 5/11

Сайншанд сум

Б.Эрдэнэчимэгийг шилжүүлэн томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дээшлүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2025 оны А/437 дугаар тушаал, Газрын даргын 2026 оны А/01 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бямбын Эрдэнэчимэгийг 2026 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн Эрдэнэ сумын газрын даамлаар шилжүүлэн томилсугай.

2. Б.Эрдэнэчимэгийн албан тушаалыг цалинг ТЗ-9 дүгээр зэрэглэлээр, албан тушаалын цалингаас төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 9 хувь, орон нутагт ажилласны нэмэгдлийг 40 хувь (Улсын төсөв), зэрэг дэвийн нэмэгдэл (гутгаар зэрэг дэс түшмэл) 20 хувиар тус тус тооцож олгохыг ерөнхий нягтлан бодогч (Д.Сайнтуяа)-д зөвшөөрсүгэй.

3. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, холбогдох хууль тогтоомжийг чанд сахиж ажиллахыг Эрдэнэ сумын газрын даамал (Б.Эрдэнэчимэг)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ОЛЗБАЯР

4426010089